



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.БАТНАСАН ТАНАА

3616 02091 4-X / 649
3618-243C -111.3 24

Хариу хүргүүлэх тухай

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24.6 дахь хэсгийг хэрэгжүүлэх талаар Таны ирүүлсэн асуулттай танилцлаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24.6 дахь хэсээт “Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэж заасан. Харин мөн хуулийн 26.1.5 дахь заалтад “аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг албан татвар төлөгч нь энэ хуулийн 16.1.12, 24.6-д заасан хөнгөлөлт эдлэх бол татварын алба ажил олгогчтой албан татварын жилийн эцсийн тооцоо хийхдээ уг хөнгөлөлтийг албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцох” гэж заасан.

Татварын алба 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш хуулийг хэрэгжүүлэхдээ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.5 дахь заалтыг үндэслэн хөнгөлөлтийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцсоор ирсэн байна.

Засгийн газар татварын 2 дахь шатны шинэчлэлийн хүрээнд Татварын
ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь
хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг
боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд ингэхдээ татварын хууль тогтоомжийг
энгийн, ойлгомжтой, хэрэгжүүлэхэд хялбар байх зарчмыг баримталж,
зөрчилтэй, хоёрдмол утга агуулга бүхий зүйл, заалтыг бий болгохгүй байх
чиглэлээр ажиллаж байгаа болно.

Хүндэтгэсэн,

Douglas

Ч.ХҮРЭЛБААТАР